
**МОНГОЛ УЛСЫН 2009 ОНЫ 3 ДУГААР
УЛИРЛЫН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргалаа. 2009 оны 3 дугаар улирлын байдлаар нэгдсэн төсвийн нийт орлогын бүрдүүлэлт 99.2 хувийн биелэлттэй, нийт зарлага 86.7 хувийн биелэлттэй гарч улмаар төсвийн нийт алдагдал 332.5 тэрбум төгрөгт хүрсэн байгаа нь төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 245.2 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдал сайжирсан байна. Засгийн газрын зүгээс хямралын эсрэг төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөөний хүрээнд эдийн засгийг тогтворжуулах, макро эдийн засгийг тэлэх чиглэлээр Монголбанктай хамтран төсөв, мөнгөний бодлогыг уялдуулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүний хүрээнд нийтдээ 106.7 орчим тэрбум төгрөгийг ЗГ-аас банкны салбард үйлдвэрлэлийг дэмжих, барилгын салбар, алт олборлогчдыг дэмжих, өдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зэрэг чиглэлээр санхүүжүүлээд байна.


Монгол Улсын Засгийн газар ОУВС-тай байгуулсан өгтөлбөрийн хүрээнд шалгуурыг үзүүлэлтүүдээ хангаж байгаа бөгөөд энэхүү хөтөлбөрийн үр нөлөөгөөр бусад харилцагч донор улс орнуудаас зээл, тусламжаар төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд эхний 9 сарын байдлаар 164.2 тэрбум төгрөгийн хөрөнгө төвлөрөөд байна.

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын байдлыг авч үзвэл:

А. Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт:

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр нийт орлого 1331.4 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 10.3 тэрбум төгрөгөөр буюу 0.8 хувиар дутуу биелж, 2008 оны мөн үеийнхээс 17.8 хувиар буюу 287.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлт
/тэрбум.төг/



Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрээр нь авч үзвэл 80.4 хувь нь татварын орлогоос, 18.4 хувь нь татварын бус орлогоос, 0.2 хувь нь хөрөнгийн орлогоос, 1.0 хувь нь тусламжийн орлогоос тус тус бүрдсэн байна.

Нэгдсэн төсвийн орлого төлөвлөгөөнөөс 10.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын орлого 20.1 хувиар буюу 31.1 тэрбум, нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 6.1 хувиар буюу 15.3 тэрбум, онцгой албан татварын орлого 10.0 хувиар буюу 12.8 тэрбум, гадаад худалдааны орлого 15.1 хувиар буюу 15.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэнтэй холбоотой байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

ТӨСВИЙН ОРЛОГО	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мөн үсийн	жилийн Төлөв.	2009 ОНЫ 3-Р УЛИРАЛ		ХУВЬ		ӨРҮҮ
	1	2	Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	(4 - 3)
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,619.1	2,054.5	1,341.7	1,331.4	99.2	64.8	-10.3
УРСГАЛ ОРЛОГО	1,607.8	2,030.2	1,323.7	1,316.4	99.4	64.8	-7.3
ТАТВАРЫН ОРЛОГО	1,414.6	1,697.6	1,079.8	1,070.9	99.2	63.1	-8.9
Орлогын албан татвар	602.9	451.8	278.1	301.0	108.2	66.6	22.8
ААН-ийн орлогын албан татвар	191.0	223.5	154.6	123.5	79.9	55.2	-31.1
Хувь хүний орлогын албан татвар	76.8	98.7	81.0	88.6	109.5	89.8	7.7
Зарим ётгээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	335.1	129.7	42.6	88.9	208.8	68.6	46.3
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	153.1	251.6	169.8	180.7	106.5	71.8	11.0
Өмчийн татвар	6.1	10.3	7.7	8.0	103.5	77.4	0.3
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	381.4	629.3	393.5	365.6	92.9	58.1	-27.9
Гадаад худалдааны орлого	114.0	163.2	99.5	84.5	84.9	51.8	-15.1
Бусад татвар	157.1	191.5	131.2	131.2	100.0	68.5	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193.2	332.6	243.9	245.5	100.7	73.8	1.6
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	2.7	2.4	3.9	2.2	56.0	92.1	-1.7
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	8.5	22.0	14.1	12.8	91.0	58.3	-1.3

Нэгдсэн төсвийн орлогын бүрдүүлэлтийг төсөв тус бүрээр авч үзвэл:

- Улсын төсвийн орлого 986.9 тэрбум төгрөгт хүрч 7.2 хувиар буюу 76.2 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс дутуу биелсэн байна. Үүнд орлогын албан татварын орлого 20.1 хувиар буюу 31.1 тэрбум, дотоодын барааүйлчилгээний албан татвар 7.5 хувиар буюу 28.9 тэрбум, гадаад худалдааны орлого 15.1 хувиар буюу 15.1 тэрбум, тусламжийн орлого 3.9 хувиар буюу 4.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу төвлөрсөн нь нөлөөлсөн байна.
- Орон нутгийн төсвийн орлого 189.7 тэрбум төгрөгт хүрч 0.3 хувиар буюу 5.1 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс илүү төвлөрсөн байна. Орлогын албан татвар 9.5 хувиар буюу 7.7 тэрбум, татварын бус орлого 11.9 хувиар буюу 1.8 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс илүү төвлөрч, бусад татварын орлого 6.8 хувиар буюу 3.9 тэрбум, хөрөнгийн орлого 44.0 хувиар буюу 1.7 тэрбум төгрөгөөр тасалдсан байна. Сэлэннэ аймгийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 1.1 тэрбум төгрөгөөр тасарч аймгийн нийт дүнгээр 1.3 тэрбум төгрөгөөр орлого тасарсан байна. Нийслэлийн бусад татварын орлого 0.9 тэрбум, хөрөнгийн орлого 1.8 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн ч, хувь хэний орлогын албан татварын орлого 4.5 тэрбум, авто тээврийн болонөөрөө явагч хэрэгслийн татвар 0.6 тэрбум, татварын бус орлого 0.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелснээр нийт дүнгээр 2.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөнөөс давж биелсэн байна. Орхон аймгийн орлого 0.8 тэрбум, Сүхбаатар аймгийн орлого 0.7 тэрбум, Баян-Өлгий,

Сверхангай, Хөвсгөл аймгуудын орлого 0.4 тэрбум тус тус давж, Булган аймгийн орлого 0.5 тэрбум, Дархан-Уул аймгийн орлого 0.3 тэрбум, Архангай, Сүмбэговь аймгуудын орлого 0.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.

- Монгол Улсыг өхжүүлэх сангийн орлогод зарим бигээгдэхүүний үнийн өсөлтийн татварын орлого 88.9 тэрбум төгрөгт хүрч төлөвлөгөөнөөс 46.3 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 344.1 тэрбум төгрөгт хүрч 3.5 хувиар буюу 8.1 тэрбум өгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлжээ. Нийгмийн даатгалын санд улсын өсвөөс олгох 117.9 тэрбум өгрөгийн татаас, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсвийн бүрэлдэхүүнээр харуулвал:

ТӨСВИЙН ОРЛОГО	Улсын өсөв		Орон нутгийн өсөв		МУХС		НДС	
	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ	ТӨЛ	ГҮЙ
	(Тэрбум.өгрөг)							
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,063.1	986.9	184.6	189.7	45.1	91.4	336.0	344.1
УРСГАЛ ОРЛОГО	940.0	868.6	168.9	175.6	45.1	91.4	218.1	226.2
ТАТВАРЫН ОРЛОГО	713.7	642.6	153.7	158.7	42.6	88.9	218.1	226.2
Орлогын албан татвар	154.6	123.5	81.0	88.6	42.6	88.9	0.0	0.0
ААН-ийн орлогын албан татвар	154.6	123.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Хувь хүний орлогын албан татвар	0.0	0.0	81.0	88.6	0.0	0.0	0.0	0.0
Зарим гтээгдэхүүний үнийн өсөлтийн а/татвар	0.0	0.0	0.0	0.0	42.6	88.9	0.0	0.0
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	218.1	226.2
Өмчийн татвар	0.0	0.0	7.7	8.0	0.0	0.0	0.0	0.0
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	385.8	357.0	7.7	8.6	0.0	0.0	0.0	0.0
Гадаад худалдааны орлого	99.5	84.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар	73.8	77.7	57.4	53.5	0.0	0.0	0.0	0.0
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	226.2	226.0	15.2	17.0	2.5	2.5	0.0	0.0
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	0.0	0.0	3.9	2.2	0.0	0.0	0.0	0.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	123.1	118.3	11.9	11.9	0.0	0.0	117.9	117.9

Б. Нэгдсэн төсвийн зарлага, санхүүжилт: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2009 оны эхний 9 сарын гүйцэтгэлээр 1919.4 тэрбум төгрөг, үүнээс улсын төсвийн зарлага 1471.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн зарлага 1663.9 тэрбум төгрөг болж, төлөвлөгдсөн нийт зарлагын 86.7 хувийг, улсын төсвийн зарлага 1 294.0 тэрбум төгрөг болж, нийт төлөвлөгдсөн зардлын 87.9 хувийг тус тус санхүүжүүлсэн байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн тавьж олгосон бөгөөд халамжийн сангаас хүүхдийн мөнгөний хөтөлбөрт 27.8 тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжинд 4.8 тэрбум төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламжинд 8.9 тэрбум төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 10.4 тэрбум өгрөг, ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, нэг удаагийн тэтгэмжинд нийт 4.8 тэрбум төгрөг, жирэмсэн нярай эхчүүдэд 11.8 тэрбум төгрөгийн, ахмад дайчдын орон сууцны дэмжлэгт 3,0 тэрбум төгрөгийн халамжийн санхүүжилтийг тус тус олгосон байна.

Нэгдсэн төсвийн нийт урсгал зардлын 12.9 хувь буюу 162.2 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардал, 36.8 хувь буюу 463.6 тэрбум төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, нийтдээ 49.7 хувь буюу 625.8 тэрбум өгрөг ийг цалин, тэтгэвэр тэтгэмжийн зардал эзэлж байна.

Орон нутгийн төсвийн зарлага 1 77.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардлын 91.6 хувийг санхүүжүүлсэн байна. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн зарлага төлөвлөгдсөн

зардлын 67.5 хувь буюу 145.3 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн зарлага төлөвлөгдсөн зардлын 100.6 хувь буюу 328.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

ӨСВИЙН ЗАРЛАГА	НЭГДСЭН ТӨСӨВ						
	ӨО-ны мон үеийн	жилийн Төлөв.	2009 ОНЫ 3-Р УЛИРАЛ		ХУВЬ		ӨРҮҮ (4 - 3)
			Төлөв.	Гүйцэт.	(4 : 3)	(4 : 2)	
	1	2	3	4	5	6	7
	(Тэрбум төгрөг)						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,622.2	2,377.7	1,919.4	1,663.9	86.7	70.0	-255.5
УРСГАЛ ЗАРДАЛ	1,225.6	1,832.2	1,403.0	1,260.3	89.8	68.8	-142.7
Бараа, үйлчилгээний зардал	699.4	932.0	734.4	685.7	93.4	73.6	-48.6
Цалин хөлс	387.9	586.7	444.1	424.3	95.5	72.3	-19.9
Нийгмийн даатгалын шимтгэл	33.7	55.7	42.2	39.4	93.1	70.6	-2.9
Бараа, үйлчилгээний бусад зардал	311.5	345.3	290.2	261.5	90.1	75.7	-28.8
Зээлийн үйлчилгээний төлбөр	13.7	54.5	24.9	20.6	82.8	37.8	-4.3
Татаас ба шилжүүлэг	512.4	845.7	643.7	554.0	86.1	65.5	-89.7
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	281.4	444.2	433.8	264.3	60.9	59.5	-169.5
Догоод эх үүсвэрээр:	268.4	412.1	408.2	250.6	61.4	60.8	-157.6
Гадаад эх үүсвэрээр	13.0	32.0	25.6	13.7	53.4	42.6	-11.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	115.2	101.4	82.7	139.3	168.5	137.4	56.6
УРСГАЛ ТЭНЦЭЛ	382.3	198.0	-79.3	56.1	(70.7)	28.3	135.4
НИЙТ ТЭНЦЭЛ	-3.1	-323.2	-577.7	-332.5	57.6	102.9	245.2

Эргэж төлөгдөх цэвэр зээл :

Монгол Улсын Засгийн газар 2009 оны 3 дугаар улирлын гүйцэтгэлээр олон улсын байгууллага, гадаадын хандивлагч орнуудаас 116.6 тэрбум өгрөгтэй тэнцэх хэмжээний төслийн зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд 61.7 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний эх үүсвэрийг авч ашигласан гүйцэтгэл гарчээ.

Төсвийн тэнцэл:

Тайлант үед Монгол Улсын нэгдсэн өсвийн урсгал тэнцэл 56.1 тэрбум өгрөг ийн ашигтай, нийт тэнцэл 332.5 тэрбум төгрөгийн алдагдалтай, улсын төсвийн урсгал тэнцэл 128.9 тэрбум, нийт тэнцэл 307.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Төсвийн нийт алдагдлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлж урсгал болон хөрөнгө оруулалтын санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн төлж барагдууллаа.

Үүнд: 1. МУ-н өсвийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эрсдлийн хэсгээс 171.8 тэрбум төгрөгийн,

2. Донор болон хандивлагч улс орнуудаас 164.2 тэрбум эх үүсвэрүүдийг бүрдүүлсэн байна.

-----oOo-----